| | |
|---|---|
| **БАТЛАВ.**<br><br>“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Т.ПҮРЭВХАТАН | |
| **ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР** | |
| **1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ** | |
| **Зөвлөх үйлчилгээний ажлын үндэслэл** | - Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол “Шинэ сэргэлтийн бодлого”<br>- Барилгын тухай хууль<br>- Барилгын ажлын захиалагчийн дүрэм<br>- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоол<br>- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 229 дүгээр тогтоол<br>- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр |
| **Зөвлөх үйлчилгээний ажлын зорилго** | Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын зорилго нь барилга угсралт, тоног төхөөрөмжийн суурилуулалт, туршилт, тохируулга, улсын комисст хүлээлгэн өгөх зэрэг төслийн бүхий л үе шатны захиалагчийн техникийн хяналт болон төслийн удирдлага, зохион байгуулалт, техник технологийн хяналт тавихад хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээ үзүүлэхэд оршино. |
| **Зөвлөх үйлчилгээний ажлын хамрах хүрээ** | Төслийг хэрэгжүүлэхдээ дараах бичиг баримтыг дагаж мөрдөнө. Үүнд:<br>- Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, 2006<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008<br>- Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, 2003<br>- Барилгын тухай хууль, 2016<br>- Үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам<br>- Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм<br>- Холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журмын дагуу гүйцэтгэх бүх ажлыг хийж гүйцэтгэнэ.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь барилга байгууламжийн төслийг төлөвлөсөн хугацаанд нь амжилттай хэрэгжүүлж дуусгахад Захиалагч болон Төслийн гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлж ажиллахаас гадна бусад холбогдох оролцогч талуудын ажлын уялдаа холбоог ханган шаардлагатай хөдөлмөр аюулгүй ажиллагааны арга хэмжээг авч ажиллана.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх төслийн барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга, улсын комисст хүлээлгэн өгөх зэрэг төслийн бүх үе шатны ажлуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журмын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж, зааварчилгаа өгөхөөс гадна төслийн хэрэгжилтийн явцад үүссэн аливаа зөрчил, дутагдлыг нэн даруй арилгуулах, чанартай гүйцэтгүүлэх шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн хяналтыг зохион байгуулах зэрэг бусад төсөл амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн төслийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхдээ удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, төслийн шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн ажиллана.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь төслийн гүйцэтгэгчийн баримталж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны бодлого, дүрэм, журам, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд шаардлагатай зөвлөмж, зааварчилгааг өгнө. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь өөрийн гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ажиллана. |
| **2 ЕРӨНХИЙ ШААРДЛАГА** | |
| **Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн** | - Зөвлөх нь барилгын ажилд байнгын хяналт тавих багийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд сахин ажиллуулна. |

| | |
|---|---|
| **этгээдэд тавигдах шаардлага** | - Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчин болон техник, тоног төхөөрөмж, барилгын үйл ажиллагаатай холбогдсон стандарт, норм, дүрэм, журмыг чандлан мөрддөг хуулийн этгээд байна.<br>- Татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн.<br>- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох бүх ажил, түүний зардлууд, татвар, төлбөр, даатгал, хураамж, тээвэр, зөвлөхийн хөлс, туслах материал, техник хэрэгсэл, ажилчдын цалин хөлс, байр, хоол, унаа гэх мэт бусад бүх зардлыг бүрэн хариуцна. Төслийг төлөвлөсөн хугацаа, төсөвт багтаан чанартай хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд зөвлөх, мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнуудыг нэмэлтээр авч ажиллуулж болно. |
| **Ажиллах бүрэлдэхүүнд тавигдах шаардлага** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь ажиллах хүчний төлөвлөгөөг боловсруулж, Захиалагч болон Төсөл хэрэгжүүлэгчид танилцуулах бөгөөд ажиллах хүчний бүтцийг болон ажилтны мэдээллийг тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад заасны дагуу тендерт ирүүлнэ. |
| **3 ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД** | |
| **Төслийн төлөвлөлтийн үе шатны ажлууд** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь Төслийн гүйцэтгэгчийн ирүүлсэн холбогдох төлөвлөгөө, төслийн баримт бичгийн иж бүрдэлтэй танилцаж, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн баримт бичгүүдийг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөн ажиллана. Үүнд:<br>- Төслийн эхлэлээс дуусах хүртэлх хугацаанд бүрэн хяналт тавихад шаардлагатай хэмжээний техникийн тодорхойлолт ба шаардлага боловсруулах<br>- Төслийн мэдээллийн сан үүсгэх (Зураг болон бусад техникийн баримт бичгүүдийг хүлээн авах, бүртгэх, хөтлөх, архивлах, түгээх, хянуулах, батлах процессуудыг удирдах г.м)<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны төлөвлөгөө<br>- Бусад шаардлагатай баримт бичгүүд |
| **Төслийн барилгын үе шатны ажлууд** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэхэд хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээ үзүүлэх бөгөөд барилга байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг хугацаанд нь чанартай, батлагдсан төсөвт багтаан гүйцэтгүүлэх болон бусад асуудлаар санал, зөвлөмж, төлөвлөгөөг захиалагчид хүргүүлж ажиллана. Үүнд:<br>- Ажилд шаардлагатай маягтуудыг боловсруулан төслийн хүрээнд ашиглахаар захиалагчид танилцуулж, хянуулан ашиглах<br>- Төслийн барилгын ажил хэрэгжилтийн хугацаанд тухайн ажлыг батлагдсан зураг төсөв, стандарт, норм, дүрэм, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэх, ажлын технологи, чанарт өдөр тутам хяналт тавихад шаардлагатай хөдөлмөр аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмж, шаардлага хүргүүлэх, биелэлтийг хангуулах ба ажлын чанар, гүйцэтгэлийг баталгаажуулан ажлын явцын талаарх мэдээллээр захиалагчийг хангах<br>- Төслийн барилгын ажлын хэрэгжилтийн явцад үүссэн хөдөлмөр аюулгүй ажиллагааны аливаа зөрчил, дутагдлыг нэн даруй арилгуулах<br>- Фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын актыг баталгаажуулж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрөл олгоход хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээний дэмжлэг үзүүлж ажиллах<br>- Барилга угсралтын ажлын техникийн хяналт хийхэд хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээ үзүүлж ажиллах<br>- Төслийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны ажлын явц, хэрэгжилтийн талаар 7 хоног тутам захиалагчтай хамтарсан хурал зохион байгуулан тэмдэглэл хөтөлж, шаардлагатай арга хэмжээг авч Захиалагчийн хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллах<br>- Шаардлагатай барилгын материалын сорилт шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх, өнгө, стандартын шаардлага хангасан өөр материал, түүхий эдээр орлуулах эсэхийг Захиалагчтай хамтран шийдэх |

| | |
|---|---|
| | - Төслийн үндсэн тоног төхөөрөмж, барилгын материалын чанар, тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалт, угсралт, суурилуулалтын ажилд хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналтыг төлөвлөгөөний дагуу хийж баримтжуулах<br>- Хөдөлмөр аюулгүй ажиллагааны баримт бичгийн бүрдэл үүсгэх, хяналт хийх<br>- Эрх бүхий байгууллагаас өгсөн шаардлага, зааварчилгааг биелүүлэх ажлыг зохион байгуулах<br>- Байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангуулах<br>- Барилгын ажлын явцад зохиогчоор хяналт хийлгэх ажлыг зохиогчийн хяналтын гэрээний дагуу зохион байгуулахад хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээ үзүүлэх<br>- Барилгын ажлын явцад Захиалагчид 7 хоног, сарын тайлан гаргаж танилцуулах болон аливаа гарсан асуудлыг тухай бүр танилцуулж шийдвэрлүүлэх, шийдвэрийг Захиалагч болон холбогдох албан тушаалтнуудад хүргэх ажлыг зохион байгуулах<br>- Барилга байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхэд Захиалагч болон Төслийн гүйцэтгэгч болон бусад холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлагатай арга хэмжээг авч ажиллах<br>- Төслийн барилгын ажилтай холбоотой аливаа маргаан, нэхэмжлэл, хохирлын талаар судалж, тайлбар, дүгнэлт, зөвлөмж гарган Захиалагчид ирүүлэх<br>- Нийт төслийн хувьд эхлэлийн, сарын, эцсийн тайланг гэрээнд заасан хугацаанд гаргаж, Захиалагчид албан бичгийн хамт ирүүлэх ба тайланд хийгдсэн ажлын тоо хэмжээ, ажлын явц, тухайн хугацаанд гарсан аливаа өөрчлөлт, санхүүжилт, цаашид авах арга хэмжээний санал, төлөвлөгөө, холбогдох фото зураг зэрэг мэдээллийг тусгасан байх<br>- Барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэх гэрээнд заасан Төслийн гүйцэтгэгчээс Захиалагчид хүлээлгэн өгөх хөдөлмөр аюулгүй ажиллагааны баримт бичгүүдийг тогтоосон хугацаанд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. |
| **Туршилт, тохируулга, улсын комисст хүлээлгэн өгөх үе шатны ажлууд** | - Тоног төхөөрөмжийн хоосон болон ачаатай туршилтын ажлыг зохион байгуулахад хөдөлмөр аюулгүй ажиллагаагаар ханган, хяналт тавих<br>- Төслийн батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан туршилт, тохируулгыг Төслийн гүйцэтгэгч болон Захиалагчтай хамтран хийж гүйцэтгэж, Захиалагчид тайлан гаргаж хүргүүлэх<br>- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах, хүлээн авах ажлыг зохион байгуулахад хөдөлмөр аюулгүй ажиллагааны үйлчилгээ үзүүлэх<br>- Барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх, барилга байгууламж, үйлдвэрийг ажиллагаанд оруулах, үйл ажиллагааны туршилтын хугацааны хяналт тавихад хөдөлмөр аюулгүй ажиллагааг хангаж зохион байгуулах<br>- Ашиглалтын хугацаанд хөтлөх хувийн хэргийг нээх, хөтлөх<br>- Төслийг бүрэн улсын комисст хүлээлгэн өгч, ашиглагч талд хүлээн авсны дараа Зөвлөх үйлчилгээний нэгдсэн тайлан буюу төслийн хаалтын бүрэн хэмжээний тайланг гарган Захиалагчид өгнө. |
| **Сургалт, зөвлөгөө** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсаны дараа Захиалагчийн төслийн багт нэн даруй төслийн удирдлагын бүрэн хэмжээний сургалтыг зохион байгуулах бөгөөд төсөл хэрэгжиж дуусахад төслийн нийт хэрэгжилтийн хугацаанд хийгдсэн ажлуудын талаар танилцуулах сургалт хийнэ. |
| **Төслийн чанарын менежмент** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь төслийн бүхий л үе шатны ажлуудад хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналт тавьж ажиллах бөгөөд төслийн төлөвлөлтийн үе шатанд хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналтын төлөвлөгөөг боловсруулж, Захиалагч болон Төсөл |

| | |
|---|---|
| | хэрэгжүүлэгчээр батлуулна. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь дараах чиглэлээр хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналтыг хийж гүйцэтгэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:<br>- Зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журмын дагуу боловсруулсан эсэхэд хяналт тавих<br>- Тоног төхөөрөмжийн угсралтын хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналт хийх<br>- Барилга угсралтыг зураг төслийн дагуу гүйцэтгүүлж, хүлээн авахад хөдөлмөр аюулгүй ажиллагааны хяналт тавих<br>- Бараа материал, тоног төхөөрөмж, химийн урвалж, бодис, тос тослох материалын хадгалалт, тээвэрлэлтэд хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналт хийх<br>- Төсөлтэй холбогдсон бусад шаардлагатай хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын хяналтын ажлууд<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны чанарын шаардлага хангахгүй ажил, үйлчилгээ, бараа материал, тоног төхөөрөмжийг чанарын шаардлагад нийцүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах бөгөөд тухай бүр Захиалагч болон Төсөл хэрэгжүүлэгчид танилцуулна. |
| **Төслийн харилцаа холбооны менежмент** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь харилцаа холбооны менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн мэдээллийг бий болгох, цуглуулах, түгээх, хадгалах бөгөөд төслийн бүхий л үе шатуудад төслийн оролцогч талуудыг мэдээллээр хангаж ажиллана. |
| **Баримт бичгийн бүрдэл, тайлагнах хэлбэр** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь тайлан бүрийг хэвлэмэл хэлбэрээр монгол, англи хэл дээр тус бүр 1 хувь, электрон хэлбэрээр 1 хувийг CD болон DVD хэлбэрээр бичиж хүлээлгэн өгнө. Бүх тайлан материалыг Microsoft Office программын сүүлийн үеийн хувилбаруудыг (Word, Excel, PowerPoint, MS-Project г.м) ашиглан бэлтгэнэ. Танилцуулгыг PowerPoint программаар бэлтгэнэ. Бүх төрлийн зургийг AutoCAD программын сүүлийн үеийн хувилбарыг ашиглан бэлтгэнэ.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь ажлын файлуудыг зүй ёсоор хадгалах ёстой бөгөөд харилцаа холбоо, хурал, уулзалт, хүлээлгэн өгсөн мэдээлэл, хүсэлт, анхан шатны болон явцын тайлангууд, төлбөрийн нэхэмжлэх, нэмэлт өөрчлөлт зэрэг гэрээний баримт бичгүүд болон бусад бүх харилцаанд дэлгэрэнгүй, тэмдэглэлийг хөтөлж, талуудаар баталгаажуулж хадгалах шаардлагатай.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь төсөлтэй холбогдсон бүх цаасан болон электрон баримт бичгийн дэлгэрэнгүй бүртгэлийг үүсгэж, бүрдүүлсэн байна. Эдгээр баримт бичгүүдийг хэрэглэх боломжтой хэлбэрээр эмхэтгэн цуглуулж, гэрээний хугацаанд үе шаттайгаар Захиалагчид хүлээлгэн өгч байх ба баримт бичгийн эцсийн хувилбаруудыг гэрээний төгсгөлд хүлээлгэн өгнө. Хүлээлгэн өгөх шаардлагатай баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралтад тусгав.<br>Гэрээний төгсгөлд баримт бичгийн бүх архивыг эмх цэгцтэй, зүй ёсоор индексжүүлж, тэмдэглэгээ үүсгэн Захиалагчид хүлээлгэн өгнө. Түүнчлэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь төслийн бүх баримт бичгүүдийн электрон хувилбарыг дэлгэрэнгүй, зохион байгуулалттайгаар индексжүүлэн мөн өөрсдийн хийж гүйцэтгэсэн эдийн засгийн болон холбогдох бүх тооцооллыг томьёотой файл хэлбэрээр Захиалагчид тохирох хэрэгсэлд хадгалан хүлээлгэн өгнө. Төслийн материалуудын эзэмшигчийн эрх, өмчлөх эрхийг Захиалагч эдэлнэ. |
| **Төслийн эрсдэлийн менежмент** | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь төслийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад холбогдох чиглэлээр мэдээлэл өгч, Захиалагчид танилцуулна. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлуудыг голлон анхаарч тусгана. Үүнд:<br>- Төслийн ажлын гүйцэтгэл<br>- Төслийн ажлын хуваарь<br>- Худалдан авалтын хуваарь |

| | |
|---|---|
| | - Чанарын хяналт<br>- Төслийн ажлын зардал<br>Түүнчлэн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд эрсдэлийг тодорхойлох, эрсдэлд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг эрэмбэлэх, эрсдэлийн эсрэг авах хариу арга хэмжээг тодорхойлох, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх ажилтан, албан тушаалтныг томилох, эрсдэлд хяналт тавих зэрэг асуудлуудыг тусгасан байна.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь эрсдэл үүссэн нөхцөлд зохих хариу арга хэмжээг авах ба авсан хариу арга хэмжээг баримтжуулж, бүртгэлжүүлэн дахин учрахаас сэргийлж, урьдчилсан арга хэмжээ авч ажиллана. |
| **Төсөл үргэлжлэх хугацаа** | Гэрээ байгуулснаас хойш 12 сар байна. |

# “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ 1

| **ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН** | |
|---|---|
| Хөдөлмөрийн Аюулгүй байдал Эрүүл Ахуй | Үйлчилгээ үзүүлэгч нь Барилгын тухай хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомжид заасан ХАБЭАБО-ны шаардлагыг чанд мөрдөж ажиллана.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад дүрмийг чанд мөрдөж, батлагдсан талбайн дүрэм журмыг дагаж мөрдүүлнэ.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүртэл нарийвчилсан инженерчлэл (DEG), талбайн инженерчлэл (FEG), худалдан авалт, барилга байгууламжийн бүх үе шатыг ажлын талбайн эрүүл ахуйн аюулгүй байдлын асуудлыг хариуцна. Энэхүү үүрэг нь ажил гүйцэтгэх явцад Үйлчилгээ үзүүлэгчийн удирддаг бүх дэд Үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарна. Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу захиалагчийн өмнөөс ХАБЭАБО-ын бүх үйл ажиллагааг төлөвлөж, боловсруулж, хэрэгжүүлж, хяналт тавина. Үйлчилгээ үзүүлэгч ХАБЭАБО-ны бодлогын зорилтод хүрэх, үндэсний хууль эрх зүй, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх, ХАБЭАБО-ын гарын авлага, ХАБЭАБО-ны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ХАБЭАБО-ны үйл ажиллагааг манлайлан, удирдана.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь ХАБЭА-ийн баримт бичгүүдэд заасан шаардлагуудын дагуу Захиалагчид зориулан нарийвчилсан хуваарийг боловсруулж, Захиалагчаар хянуулж батлуулна. Үйлчилгээ үзүүлэгч нь Ханган нийлүүлэгчидтэй ХАБЭА-ийн талаар хэрхэн харилцах тэмдэглэлийг нарийвчилсан байдлаар тодорхой зааж өгнө. |
| 1.1. ХАБЭА-ийн гарын авлага (HSEM) | Ажлыг гүйцэтгэхийн тулд дагаж мөрдөх ХАБЭА-ийн талаарх ойлголтыг тайлбарласан гарын авлагыг Үйлчилгээ үзүүлэгчид өгнө. Үйлдвэрлэлд нэвтэрсэн сайн туршлага болон Монгол Улсад дагаж мөрддөг бүхий л норм, зохицуулалт, шаардлага, хэрэгжүүлэх хууль ёсны заавар, зөвлөгөөг ХАБЭА-ийн гарын авлагад оруулна. ХАБЭА-ийн боловсон хүчний байгууллага (үүрэг хариуцлага, онцлог, үүрэг даалгавар, харилцаа холбоо гэх мэтийг) шаардлагатай мэдээллийг ХАБЭА-ийн гарын авлагад оруулах асуудлыг хариуцна.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь түүний ХАБЭА-ийн удирдлага менежментийн системтэй уялдуулан туслан Үйлчилгээ үзүүлэгчийн ХАБЭА-ийн удирдлага менежментийн системийг боловсруулж, уг системийг хэрэгжүүлэхэд хяналт тавина. Үйлчилгээ үзүүлэгчийн боловсруулсан ХАБЭА-ийн баримт бичгийг туслан Үйлчилгээ үзүүлэгч ашиглах боломжтой байна. Үйлчилгээ үзүүлэгч нь бүх ажлын байранд мөрдөх ХАБЭА-ийн дүрэм, журам боловсруулна. Шаардлагын дагуу ХАБЭА-ийн удирдлага менежментийн системийг хянаж сайжруулна. Үйлчилгээ үзүүлэгч нь нийтлэг гарах эрсдэлийн менежментийн процесс ажиллагааг боловсруулж, хэрэгжүүлнэ. Уг процесс, ажиллагааг барилгын ажлын Үйлчилгээ үзүүлэгч болон Дэд Үйлчилгээ үзүүлэгчийн аль аль нь дагаж мөрдөнө. Үйлчилгээ үзүүлэгчийн байгууллагын бүх шатны албан хаагчид үйл ажиллагааны эрсдэлийг ойлгож, дүрэм журмыг дагаж гүйцэтгэж, хүнийг гэмтээх, хохироох, эд зүйлийн хохирол учруулах, байгаль орчинд хохирол учруулах аливаа үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, аливаа осол гарах эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд Үйлчилгээ үзүүлэгч хяналт тавина.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн талбайд байгаа болон түүний ойролцоо байгаа бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангана.<br>Эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч инженер техникийн ажилчид, Үйлчилгээ үзүүлэгчид болон төсөл дээр ажиллаж буй бусад талуудад бэлэн байлгана. Үйлчилгээ үзүүлэгч нь барилгын ажлын явцад туслах ажилтанг хариуцах аюулгүй ажиллагааны тусгай ажилтан ажиллуулна. |
| 1.2. Аюулгүй байдлын төлөвлөгөө | Талбайн ажил эхлэхээс өмнө Үйлчилгээ үзүүлэгч нь дараах зүйлийг багтаасан Аюулгүй ажиллагааны иж бүрэн төлөвлөгөөг Захиалагчид танилцуулан хянуулж, батлуулна.<br>- Аюулгүй ажиллагааны зохион байгуулалт<br>- Аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт |

| | |
|---|---|
| | - Аюулгүй ажиллагааны дүрэм, журам<br>- Аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг<br>- Хувийн хамгаалах хэрэгсэл<br>- Осол/ослын судалгаа<br>- Яаралтай тусламжийн бэлэн байдал<br>Аюулгүй ажиллагааны практик ажиллагааг тодорхойлохын тулд холбогдох гэрээ, хууль тогтоомж, практик дүрэм, стандарт, журам, удирдамжийг ашиглана. Үйлчилгээ үзүүлэгч нь барилгын Үйлчилгээ үзүүлэгчийн өгсөн аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг хянах, аюулгүй ажиллагааны төлөвлөгөөний бүрэн хэрэгжилтийг хангана. |
| 1.3. Аюулгүй ажиллагааны зохион байгуулалт | Аюулгүй ажиллагааны зохион байгуулалтын бүтэц, ажиллах хүчний нөөц нь дэд Үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулан бүх шатны ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйн үүргийг тодорхой тусгана. Аюулгүй байдлын томилогдсон ажилтнууд болон туслах ажилтнуудыг томилох, аюулгүй ажиллагааны үүрэг хариуцлагын гарын үсэг зурах зохицуулалтыг тодорхой заана. Бүх түвшний ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх тогтмол харилцааг мэдээлж, тайлагнана. Үйлчилгээ үзүүлэгч нь ажлын хэсэг тус бүрийн аюулгүй байдлын төлөөлөгчдийн нэрийг багтаасан аюулгүй байдлын ажиллагааны зохион байгуулалтын шинэчилсэн схемийг сар тутамд захиалагчид өгнө. Эдгээр аюулгүй байдлын ажилтнуудын утасны дугаарыг схемд оруулна. |
| 1.4. Аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын журам | Бүх ажилтнуудыг зохих ёсоор ажиллуулах, аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий сургалт, ажил үүрэгтэй холбоотой ажлын тусгай сургалтад хамруулахын тулд сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулна. Байнгын сургалтын давтамж, хамрах хүрээ, хэрэглээг тодорхойлох хөтөлбөрийг гаргана. |
| 1.5. Аюулгүй ажиллагааны дүрэм журам | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг Аюулгүй байдлын ажилтнууд болон Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнууд авч танилцах боломжтой байна. Үүнд: Захиалагч болон эрх бүхий гуравдагч этгээдийн тогтоосон аюулгүй ажиллагааны дүрэм, журам, түүнчлэн талбайд зочлох эрх бүхий зочдыг хамгаалах аливаа журам орно. Дүрэм, журмын холбогдох заалтыг талбайд ажиллаж буй бүх түвшний ажилтнуудад мэдээлнэ. Дагаж мөрдөхтэй холбоотой сахилгын арга хэмжээ авах хэрэгслийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.<br>Барилга байгууламж дээр аюулгүй байдал, нэвтрэх шаардлагад онцгой анхаарал хандуулна. Үйлчилгээ үзүүлэгч нь урьдчилан тохиролцсоны дагуу Захиалагчтай хамтран Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнууд болон туслан Үйлчилгээ үзүүлэгчдийн ажилчдад холбогдох бүх журмыг чанд мөрдүүлнэ. |
| 1.6. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналт шалгалт | Аюултай нөхцөл байдлыг тодорхойлох, бүртгэх, мэдээлэх, тэдгээрийг засан залруулах, арилгах асуудлыг тогтоох зохицуулалтыг хийнэ. Үүнд:<br>- Аюулгүй байдлын ажилтнууд, хяналтын ажилтнууд болон дээд удирдлагын хийх шалгалтын давтамж, хамрах хүрээ, хэмжээ<br>- Илэрсэн зөрчил, аюулыг бүртгэн аюулгүй байдлын хяналт шалгалтанд ашиглах аюулгүй байдлын иж бүрэн хяналтын хуудас<br>- Зөрчлийн талаар мэдээлэх схем, зохих ажилтнуудаас шуурхай залруулах арга хэмжээ авах<br>- Цахилгаан байгууламжийн ойролцоо гагнах, өргөх, ажиллуулах гэх мэт өндөр эрсдэлтэй үйл ажиллагаатай холбоотой урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний хөтөлбөр. |
| 1.7. Аюул, ослын эрсдэлийн шинжилгээ | Төслийн Үйлчилгээ үзүүлэгч нь туслан Үйлчилгээ үзүүлэгч байгаа бол түүнтэй хамтран гүйцэтгэлийн ажлын тодорхой хэсгүүдтэй холбогдох эрүүл мэнд, аюулгүй байдал, эрсдэлийг тодорхойлно. Үйлчилгээ үзүүлэгч ажил эхлэхийн өмнө эдгээр эрсдэлийг хангалттай арилгах, багасгах, хяналтдаа авах ажлын журам, арга зүйг хянана. Холбогдох ажлыг явуулахад найдвартай байдлыг хангах, зохих арга хэмжээг авсан зэрэг байдлыг хангахын тулд тухайн эрсдэлийн үнэлгээг тогтмол хянах журам, аюулгүй ажиллагааны журам, арга зүйн зөвлөмжийг боловсруулан дагаж мөрдөнө.<br>Осол аваарын хяналт тавих, аюулыг арилгах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ гэдэгт аюулгүй ажиллагааны дүрэм, журам, аюулгүй ажиллах журам, |

| | |
|---|---|
| | арга зүй, аргачлалын зөвлөмж, ажиллах зөвшөөрлийн системийг багтаан ойлгох бөгөөд өндөр эрсдэлтэй процессийн үйл ажиллагааны хувьд хийх эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үүнд оруулж тооцох боловч зөвхөн үүгээр хязгаарлахгүй дараах эрсдэлийг ойлгоно. Аюул, ослын шинжилгээг дангаар ажиллаж байгаа хүний хийж чадах эсэх ажиллагаа гэдгийг тогтооно. |
| 1.8. Хувийн хамгаалах хэрэгсэл | Үйлчилгээ үзүүлэгч ба түүний ажилтан нарын гүйцэтгэх тодорхой чиг үүрэг, даалгаврыг харгалзан хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах, сонгох журмыг тогтооно. |
| 1.9. Осол ба ослын судалгаа | Осол гэмтэл, осол, түүний дотор талбайд гарсан аюул эрсдэлтэй ослын тохиолдлыг шуурхай мэдээлэх, бүртгэх, мөрдөн шалгах журмыг тогтооно. Үүнд чиг хандлагыг тодорхойлох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах зорилгоор ослын статистик, дүн шинжилгээ хийх шаардлагатай. Осол гэмтэл давтагдахаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг талбайд ажиллаж байгаа бүх хүмүүст өгөх, олж авсан сургамжаа хуваалцах арга хэрэгслийг тогтооно. |
| 1.10. Онцгой байдлын үеийн бэлэн байдал | Аюулгүй байдлын төлөвлөгөөнд хүчтэй аадар бороо, хүчтэй шороон шуурга, газар хөдлөлт, хэт хүйтэн, иргэний үймээн самуун, дэгдэлт, гал түймэр гэх мэт аюул эрсдэлтэй нөхцөл байдалд Онцгой байдлын албыг ирэхээс өмнө шаардлагатай аврах арга хэмжээ,нөхцөл байдлыг шийдвэрлэх журмыг багтаана. Аюулгүй байдлын төлөвлөгөөнд дараах журмыг баримтална. Үүнд:<br>- Талбай дээрх бүх ажилчдад яаралтай тусламжийн горимыг мэдээлэх.<br>- Онцгой байдлын болон/эсвэл аврах багуудын сургалт.<br>- Онцгой байдлын үед авах арга хэмжээний жагсаалт.<br>- Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангах ба тэдгээрийн байршил.<br>- Анхны тусламж үзүүлэх ажилтнууд болон тоног төхөөрөмжийг тодорхойлох, үүнд шархадсан хүмүүсийг тээвэрлэх зохицуулалт орно.<br>- Онцгой байдлын журам, утасны жагсаалтыг хянаж, тогтмол шинэчилнэ. |
| 4.1.11. Төслийн эрсдэлийн бүртгэл: | Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэлүүд Мониторинг болон тайлагналын зорилгоор төслийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө (PRMP) -ийг зохиож эмхэтгэнэ. Өндөр түвшний бүх эрсдэлийг менежментийн багийн хянан шалгах төслийн эрсдэлийн ерөнхий бүртгэлд оруулна. Эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн менежментийн амжилт, алдаа дутагдлын дүн шинжилгээг тасралтгүй сайжруулах үйл явцын нэг хэсэг болгон баримтжуулна. Ийм эрсдэлийг анхааран авч үзэж эрсдэлийг бууруулах үйл явцыг нарийвчлан тодорхойлж, бүртгэж, хэрэгжүүлнэ. Эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны бүхий л асуудлыг хамруулан сайн тодорхойлсон, баримтжуулсан хяналтын үйл явцыг хэрэгжүүлнэ. |
| 4.1.12. Галаас хамгаалах ерөнхий тайлан | Захиалагч ба даатгалын шаардлагын нэг хэсэг болох уг төслийг барьж байгуулах, ашиглалтад оруулах явцад гарах галын аюулыг Гал түймрээс хамгаалах тайланд оруулан баримтжуулна. Мөрдөгдөж буй галын стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хянана.<br>Үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчийн ЭМААБО-ны багийн зааврын дагуу гал унтраах цэг байгуулж, шаардлагатай бол гал унтраах хэрэгслийг байрлуулна. Үйлчилгээ үзүүлэгчийн бүх ажилтнууд гал унтраах хэрэгслийг ашиглах сургалтад хамрагдана. |
| 4.1.13. Аюулгүй ажиллагааны хурал, тайлан | Төслийн бүтээн байгуулалтын үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хамгаалалт, аюулгүй байдлын хурлыг долоо хоног бүр хийнэ. Хурлын явцыг тэмдэглэнэ. Хурлын үеэр хэлэлцэх гэж буй ХАБ ослууд болон гэмтэл, бэртлийн давтамжийн түвшингийн статистик мэдээллийг хэлэлцэн, бүртгэнэ. Нэмэлт мэдээлэлд дараах багтана.Үүнд:<br>- Төсөлд бүртгэгдсэн бүх осол, осол дөхсөн тохиолдлуудыг судалж, мэдээлэх Ослын бүртгэл хөтөлж, шинэчилж байх.<br>- Бүх Үл нийцлийн тайлангийн бүртгэлийг бүрдүүлж, тогтмол шинэчилж байх.<br>- Ирээдүйн ослын тохиолдлыг бууруулах зорилгоор ослын шалтгааныг шийдвэрлэхэд чиглэсэн буй аливаа чиг хандлага, төлөвлөгөөг тодорхойлохын тулд ХАБ-ын мэдээллийн шинжилгээг хийнэ. |
| 4.1.14. Эрүүл | Барилга угсралтын үе шатанд ажиллах Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны |

| | |
|---|---|
| ахуй, аюулгүй ажиллагааны менежер, аюулгүй ажиллагааны ажилтнууд | менежер, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтнуудыг төсөл хэрэгжиж буй талд зохих ёсоор бүртгүүлнэ.<br>Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежер, эрүүл ахуй, аюулгүй байдлын ажилтнууд талбайд хийж буй бүх үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны цогц шалгалт, үзлэг шалгалтыг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэнэ. Захиалагчтай харилцан тохиролцсон хяналтын хуудсыг ашиглан аюулгүй ажиллагааны хяналт шалгалтаар аюултай ажиллагаа, болзошгүй аюул эрсдэлийг тодорхойлно. Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежерт олгосон эрх мэдэл нь түүнд сайтын аюулгүй байдлыг хангах, аюултай ажлын дадал зуршлаас урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай, зохих арга хэмжээг авах боломжийг олгоно. Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежер нь бүх аргачлалын мэдэгдлийг хянаж, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны системийг ажиллуулахыг зөвшөөрнө. Ийм үйл ажиллагаанд ихэвчлэн өндөр хэмд ажиллах ажил, цахилгааны ажил, хязгаарлагдмал орчинд ажиллах, шатамхай/хортой шингэн, хий ялгаруулах гэх мэт багтана. Эрүүл мэнд, ажиллагааны ажилтнууд тогтмол үзлэг шалгалт хийж, аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтын тайланг (гэрэл зургийн хамт) бэлтгэнэ. Мөн аюулгүй ажиллагааны талаарх өдрийн тэмдэглэл хөтлөх бөгөөд энэ нь аюулгүй ажиллагаатай холбоотой бүх асуудлыг бүртгэнэ. Аюулгүй ажиллагааны өдрийн тэмдэглэлийг захиалагчийн хүсэлтээр шалгаж болно. Үйлчилгээ үзүүлэгч нь аюулгүй ажиллагааны менежерийг тухайн газар дээр ажиллаж буй хэн нэгэнд аюултай үйл ажиллагааг зогсоох, тухайн газар, ажлыг аюулгүй болгохын тулд яаралтай арга хэмжээ авах, эсхүл аюулгүй байдлын төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны шаардлага, хууль тогтоомжийг зөрчсөн аливаа практик ажиллагааг хориглох тушаал өгөх эрхийг олгох үүрэгтэй. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежер болон ажилтнуудын цаашдын ажил үүрэгт дараах багтана. Үүнд:<br>- Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хянан удирдах<br>- Үйлчилгээ үзүүлэгчийн ажилчид, туслан Үйлчилгээ үзүүлэгчид болон талбай дээр ажиллаж буй бүх хүмүүст Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, дагаж мөрдүүлэх<br>- Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөнд заасан аюулгүй ажиллагааны дотоод аудитыг хамгийн бага давтамжтайгаар хийх<br>- Аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалт, осол, аюултай осол, тохиолдол, аюулгүй ажиллагаатай холбоотой осол, эндэгдэл болон түүнтэй адил тохиолдлын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тайлан, статистикийг нэгтгэн боловсруулах<br>- Аюултай бүх нөхцөл байдлыг яаралтай засаж залруулж, дуусан огноог аюулгүй ажиллагааны дэвтэрт зохих ёсоор тэмдэглэнэ.<br>Хэрэв Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежер эсвэл Эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтнууд аливаа шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй бол тэдгээрийг аль болох богино хугацаанд бөгөөд ямар ч тохиолдолд 14 хоногийн дотор өөрчилнө. Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежер, ажилтнуудыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр чөлөөлж өөрчилж болохгүй. |

# “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ 2

**Шаардлагатай бичиг баримтууд**

| Баримт бичгийн жагсаалт | | Шаардлагатай хугацаа | Хэвлэмэл хувь | Файлын төрөл |
|---|---|---|---|---|
| А хэсэг – Барилга угсралтын ажлаас өмнөх | | | | |
| 1 | Чанарын хяналтын төлөвлөгөө<br>А. Үе шатны үзлэг, туршилтын төлөвлөгөө<br>Б. Техникийн шаардлага боловсруулах<br>В. Материал баталгаажуулалт | Ажил эхлэхээс 7 хоногийн өмнө | 2 | PDF, эх файл |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны төлөвлөгөө | Ажил эхлэхээс 7 хоногийн өмнө | 2 | PDF, эх файл |
| Б хэсэг - Барилга угсралтын үед | | | | |
| 1 | Долоо хоногийн тайлан | 7 хоног бүрийн 2 дахь өдөр | 1 | PDF, эх файл |
| 2 | Сарын тайлан | Сар бүрийн эхний 7 хоногт | 1 | PDF, эх файл |
| 3 | Гүйцэтгэлийн явцын тайлан | 7 хоног бүр | 1 | PDF, эх файл |
| 4 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны тайлан | 7 хоног бүр | 1 | PDF, эх файл |
| В хэсэг - Ажиллагаанд залгах үед | | | | |
| 1 | Улсын комисс ажиллуулах, баримт бичгийн бүрдлийг хүлээлцэх, акт үйлдэх | Барилга байгууламж бүрээр | 1 | PDF, эх файл |
| 2 | Зөвлөх үйлчилгээний нэгдсэн тайлан | Төслийн гүйцэтгэгчийн гэрээг дүгнэснээс хойш 30 хоногийн дотор | 1 | PDF, эх файл |

# “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ 3

Шалгарсан компани нь ажил эхлэх үед Хүснэгтэд заасан ажиллах хүчийг бүрдүүлсэн байна.

| № | Албан тушаал | Хүний тоо | Мэргэжил | Үндсэн ажилтан эсэх | Ажлын туршлага |
|---|---|---|---|---|---|
| 1 | ХАБЭА-н төслийн ахлах мэргэжилтэн | 1 | ХАБЭА-н менежментийн чиглэлээр мэргэшсэн барилгын инженер | Үндсэн ажилтан байх | 10-аас доошгүй жил ажилласан, ХАБЭА, БО-ны чиглэлээр мэргэшсэн, 3-аас доошгүй төсөл хөтөлбөр дээр ХАБЭА-н баг удирдаж ажилласан туршлагатай байх |
| 2 | ХАБЭА-н мэргэжилтэн | 2 | ХАБЭАБО-ын чиглэлээр мэргэшсэн барилгын инженер болон экологийн инженер | Үндсэн ажилтан болон гэрээт ажилтан | 5-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн зэрэгтэй байх |

БОЛОВСРУУЛСАН:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БИЛЭГЖАРГАЛ